



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2020 Э-сонин

02-Р САР

91-р дугаар






Зах зээлийн тойм


/2021.02.28-ны өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	19
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	32,019,162,684.56
Хувьцаа /хоёрдогч/	31,257,978,749
Багцын арилжаа	0
Хөрөнгө оруулалтын сан /хоёрдогч/	363,103,285.43
ХБҮЦ /анхдагч/	0
ХБҮЦ /хоёрдогч/	16,441,410
Компанийн бонд /хоёрдогч/	381,639,240
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	
Хувьцаа /хоёрдогч/	117,074,977
Багцын арилжаа	0
Хөрөнгө орцлалтын сан /хоёрдогч/	2,311,897
ХБҮЦ /анхдагч/	0
ХБҮЦ /хоёрдогч/	41
Компанийн бонд /хоёрдогч/	3,802
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	33,831


TOP-20 индекс




Зах зээлийн үнэлгээ



MSE A индекс



MSE B индекс



БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС

1. Нийт үнэт цаас	195
100% төрийн өмчит	17
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	165
I ангилал	18
II ангилал	42
III ангилал	134
Компанийн бонд	1
Хөрөнгө оруулалтын сан	1
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	1

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	53
Үүнээс: Брокер, Дилер	53
Андеррайтер	17
Хөрөнгө оруулалтын зөвлөх	14



АРИЛЖААНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦСОН ГИШҮҮН ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУД

/2021.02.28-ны байдлаар/

	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (төг)
		Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	
1	АРД СЕКЮРИТИЗ ХХК	56,317,156	21,017,278,148	53,723,550	21,689,893,406.37	42,707,171,554.16
2	СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ХХК	18,598,912	3,521,032,786	18,430,314	2,319,673,411.06	5,840,706,197.33
3	БИДИСЕК ХК	9,841,840	1,640,074,127	11,411,904	2,058,834,938.21	3,698,909,064.91
4	БУМБАТ-АЛТАЙ ХХК	5,300,565	906,566,013	3,297,084	1,019,470,322.06	1,926,036,335.48
5	ГОЛОМТ КАПИТАЛ ХХК	11,276,315	783,296,679	9,798,218	875,986,928.85	1,659,283,607.75
6	АРД КАПИТАЛ ГРУПП ХХК	3,064,635	813,508,119	4,638,068	748,905,861.26	1,562,413,980.57
7	ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК	4,032,756	812,318,425	3,466,341	649,226,247.55	1,461,544,672.79
8	МИРЭ ЭССЕТ СЕКЮРИТИС МОНГОЛ ХХК	2,854,565	665,103,320	3,988,955	703,513,933.12	1,368,617,253.50
9	АПЕКС КАПИТАЛ ҮЦК	3,370,261	471,595,707	4,933,385	745,605,897.38	1,217,201,604.34
10	ГАУЛИ ХХК	315,726	544,306,878	712,663	218,715,014.69	763,021,893.10
11	ГҮҮДСЕК ХХК	714,992	177,033,898	434,306	182,999,823.15	360,033,721.10
12	МОНСЕК ХХК	939,548	126,981,621	805,214	120,736,327.77	247,717,948.33
13	НОВЕЛ ИНВЕСТМЕНТ ХХК	378,145	134,023,800	394,883	100,150,921.45	234,174,721.57
14	ТУЛГАТ ЧАНДМАНЬ БАЯН ХХК	90,437	12,101,331	103,253	126,834,804.78	138,936,135.52
15	БЛҮМСБЮРИ СЕКЮРИТИЕС ХХК	79,312	46,712,932	247,610	70,291,472.67	117,004,404.79
16	ГРАНДДЕВЕЛОПМЕНТ ХХК	1,097,392	76,366,099	450,163	37,216,816.60	113,582,915.62
17	ДАРХАН БРОКЕР ХХК	48,948	11,986,665	52,544	81,231,129.92	93,217,794.61
18	ЗЭРГЭД ХХК	139,805	25,336,345	168,260	34,062,529.41	59,398,873.91
19	ЦЕНТРАЛ СЕКЮРИТИЙЗ ҮЦК	8,883	6,525,145	845,044	45,835,378.14	52,360,522.94
20	БАТС ХХК	156,700	28,288,655	64,128	12,148,597.95	40,437,253.30

ИДЭВХТЭЙ АРИЛЖИГДСАН ХУВЬЦАА

/2021.02.28-ны байдлаар/

№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн (төг)	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /% /
1	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,776,843	15,500,373,219	12,200.00	2,940.00	252.67
2	AIC	АРД ДААТГАЛ ХК	5,071,305	4,889,451,485	1,590.00	850.00	67.38
3	ADB	АРД КРЕДИТ ББСБ ХК	42,208,569	4,287,408,308	238.00	82.99	158.69
4	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	21,511,313	1,272,884,811	77.02	47.80	41.68
5	APU	АПУ	1,593,751	1,121,785,641	770.00	625.00	17.11
6	SON	СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП	13,609,015	1,022,039,312	95.00	75.00	18.75
7	BDS	БИ ДИ СЕК	567,622	735,749,435	920.00	830.00	-5.50
8	LEND	ЛЭНДМН ББСБ ХК	10,709,288	414,896,240	50.00	31.13	37.82
9	XOC	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН	2,311,897	363,103,286	188.19	106.50	51.44
10	TUM	ТҮМЭН ШУВУУТ	1,556,695	325,926,735	245.00	180.00	18.81
11	MFC	МОНОС ХҮНС	3,485,459	241,433,242	79.99	64.00	-3.02
12	BODI	БОДЬ ДААТГАЛ	1,337,265	172,115,563	140.00	123.00	5.69
13	GOV	ГОВЬ	756,097	170,290,112	250.00	190.50	9.02
14	TTL	ТАВАН ТОЛГОЙ	19,403	149,204,855	8,500.00	7,000.00	12.70
15	SUU	СҮҮ	563,205	117,188,367	219.00	202.20	6.47
16	HCH	Е-МОНИЕ	52,925	115,323,575	2,179.00	2,179.00	0.00
17	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	114,570	112,356,570	999.99	950.00	1.39
18	NEH	ДАРХАН НЭХИЙ	7,506,910	108,066,712	20.50	13.40	31.09
19	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	104,869	80,328,521	849.00	740.00	9.59
20	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ ХК	312,404	56,185,967	200.00	174.00	1.36



ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ ХУВЬЦАА

/2021.02.28-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт /%/
			2021-01-29	2021-02-28		
1	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,776,843	3,000.00	10,580.00	7,580.00	252.67
2	АРД КРЕДИТ ББСБ ХК	42,208,569	83.51	216.03	132.52	158.69
3	СОНСГОЛОН БАРМАТ	75	1,086.00	2,500.00	1,414.00	130.20
4	НИЙСЛЭЛ ӨРГӨӨ	102	1,900.00	3,400.00	1,500.00	78.95
5	АРД ДААТГАЛ ХК	5,071,305	848.97	1,421.00	572.03	67.38
6	МОНГОЛ ШИЛТГЭЭН	540	220.00	350.00	130.00	59.09
7	ЭРДЭНЭС СОЛЮШИНС	316,907	53.00	83.00	30.00	56.60
8	БЭРХ УУЛ	570	598.00	916.00	318.00	53.18
9	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН	2,311,897	110.00	166.58	56.58	51.44
10	СИЛК НЕТ	112	828.00	1,250.00	422.00	50.97
11	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	35	3,254.00	4,761.00	1,507.00	46.31
12	УБ-БҮК	76,769	424.58	612.03	187.45	44.15
13	МАНДАЛ ДААТГАЛ	21,511,313	48.46	68.66	20.20	41.68
14	ЛЭНДМН ББСБ ХК	10,709,288	32.60	44.93	12.33	37.82
15	АВТО ИМПЕКС	191	1,120.00	1,500.00	380.00	33.93
16	ГОНИР	99	900.00	1,190.00	290.00	32.22
17	УЛААНСАН	17	830.00	1,095.00	265.00	31.93
18	ГАН ХИЙЦ	9	9,000.00	11,840.00	2,840.00	31.56
19	ДАРХАН НЭХИЙ	7,506,910	14.89	19.52	4.63	31.09
20	ЭРДЭНЭТ АВТО ЗАМ	72	360.00	471.50	111.50	30.97

ХАНШИЙН БУУРАЛТТАЙ ХУВЬЦАА

/2021.02.28-ны байдлаар/


№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %
			2021-01-29	2021-02-28		
1	ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГ	95	1,450.00	850.00	-600.00	-41.38
2	ШИВЭЭ ОВОО	584	1,999.00	1,660.00	-339.00	-16.96
3	ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ	2,956	143.00	120.00	-23.00	-16.08
4	ХАРХОРИН	21	1,480.00	1,260.00	-220.00	-14.86
5	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	404	27,680.00	24,860.00	-2,820.00	-10.19
6	МОНГОЛ СЕКЮРИТИЕС	45	250.00	226.00	-24.00	-9.60
7	ХӨВСГӨЛ УСАН ЗАМ	59	494.00	450.00	-44.00	-8.91
8	ЖЕНКО ТУР БЮРО	63,764	82.00	75.00	-7.00	-8.54
9	ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ	147,511	18.50	17.00	-1.50	-8.11
10	МЕРЕКС	11,825	25.00	23.00	-2.00	-8.00
11	БАГАНУУР	4,312	1,151.00	1,060.00	-91.00	-7.91
12	ТАЛХ ЧИХЭР	1,419	15,500.00	14,460.00	-1,040.00	-6.71
13	МАТЕРИАЛИМПЕКС	383	7,800.00	7,295.00	-505.00	-6.47
14	ТАВ	19	19,000.00	17,800.00	-1,200.00	-6.32
15	БИ ДИ СЕК	567,622	899.50	850.02	-49.48	-5.50



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, ТОП-20 ИНДЕКС ТҮҮХЭН ДЭЭД ХЭМЖЭЭНД ХҮРЛЭЭ




ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ



Дотоодын үнэт цаасны зах зээлийн чиг хандлага, хэмжээг тодорхойлогч гол үзүүлэлт болох ТОП-20 индекс нь 2011 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 32,954.97 нэгж, зах зээлийн үнэлгээ 3,547,710,076,404 төгрөгт хүрсэн нь түүхэн дээд үзүүлэлт болж байсан бол 2021 оны 2-р сарын 25-ны өдөр ТОП-20 индекс 34116.86 нэгж, зах зээлийн үнэлгээ 3,561,093,284,790.06 төгрөгт тус тус хүрсэн нь Монголын хөрөнгийн бирж үүсэн байгуулагдсанаас хойшхи 30 жилийн хугацааны түүхэн дээд үзүүлэлт боллоо.



ТОП 20 ИНДЕКС



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН 90 ОРЧИМ ХУВЬ НЬ ОНЛАЙНААР АРИЛЖААНД ОРОЛЦОЖ БАЙНА

Монголын хөрөнгийн зах зээлд олон улсын жишигт нийцсэн Миллениум Ай Ти цогц систем 2012 онд нэвтэрснээр хөрөнгө оруулагчид гар утас, компьютер, таблет гэх мэт дурын цахим төхөөрөмж ашиглан онлайнаар арилжаанд шууд оролцох боломжтой болсон бөгөөд жил ирэх тусам онлайнаар арилжаанд оролцогчдын тоо эрчимтэй нэмэгдэж байна.

Тухайлбал, 2019 онд Монголын хөрөнгийн биржийн арилжаанд оролцож буй хөрөнгө оруулагчдын 33 хувь, 2020 онд 70 хувь нь онлайнаар оролцож байсан бол 2021 оны 2 дугаар сарын байдлаар Монголын хөрөнгийн биржийн арилжаанд өдөрт дунджаар 2500 орчим иргэн, ААН оролцож байгаагийн 85-90 хувь нь МХБ-ийн

ҮЙЛ ЯВДАЛ

гишүүн үнэт цаасны 9 компаниар зуучлуулан онлайнаар арилжаанд оролцож байна.

Ийнхүү Ковид-19 цар тахлын улмаас Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн энэ цаг үед иргэд, аж ахуй нэгжүүд цахим хэрэглээнд шилжиж, үнэт цаасны арилжаанд оролцож байгаа нь цаашид хөрөнгийн зах зээл тэлэх, хөгжих явцад эергээр нөлөөлж, иргэдийн идэвх оролцоо, сонирхол нэмэгдэх чухал хөшүүрэг болж байна.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧДЫН АНХААРАЛД

Иргэд “Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн ARD аппликейшний DAX платформ дээр арилжигдаж буй AARD тэмдэглэгээ бүхий токенийг Монголын хөрөнгийн бирж (МХБ)-ийн 2-р ангилалд бүртгэлтэй “Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн үнэт цаастай адилтгах, андууран худалдан авах тохиолдлууд гарч, энэ тухай мэдээлэл, тодруулга хүссэн иргэд МХБ-д ихээр хандах болсонтой холбогдуулан МХБ нь дараах тайлбарыг гаргаж байна.

МХБ-д 1996 онд анх бүртгэгдсэн “Жинст Увс” ХК нь 2019 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаараа “Ард санхүүгийн нэгдэл” ХХК-ийг нэгтгэх тухай шийдвэр гаргаж, тус шийдвэрийн дагуу компанийн оноосон нэр “Ард санхүүгийн нэгдэл” ХК болж өөрчлөгдөн 2019 оны 8 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн AARD симболтойгоор МХБ дээр арилжигдаж байгаа бөгөөд МХБ дээр тус компанийн нийт 28,614,263 ширхэг үнэт цаас бүртгэлтэй байна.

МХБ нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдсэн үнэт цаасыг арилждаг бөгөөд арилжигдсан үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК нь хийж гүйцэтгэдэг. Одоогоор МХБ дээр арилжигдаж буй үнэт цаасыг токенжуулан блокчейн технологиор дамжуулан арилжих, өмчлөх эрхийг бүртгэх, хадгалахтай холбоотой зохицуулалт байхгүй, хууль эрх зүйн орчин бүрэлдээгүй байна.

Иймд, МХБ дээр арилжигдаж буй AARD симбол бүхий үнэт цаас болон “Ард санхүүгийн нэгдэл” ХХК-ийн DAX платформ дээр арилжигдаж буй AARD токен нь хоорондоо ялгаатай болохыг анхаарч, хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргана уу.



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛЭЭС АНХНЫ ГАВЬААТ ЦОЛТОН ТӨРЛӨӨ



“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн болон МҮЦАЭХ-ны удирдлагууд Монгол улсад Хөрөнгийн зах зээл үүсч “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК байгуулагдсаны 30-н жилийн ойг тохиолдуулан Гавьяат эдийн засагч цолоор шагнагдсан Очирбатын Батбилэгийг хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. О.Батбилэг нь Монголын Хөрөнгийн Биржийг анх байгуулагдахад Монголын Хөрөнгийн Биржийн Гүйцэтгэх захирлын 01 тоот тушаалаар биржийн нягтлан бодогчоор томилогдон ажилласан бөгөөд 1991-2000 оны 9 дүгээр сар хүртэл ажиллахдаа нягтлан бодогч, Санхүүгийн албаны дарга, Хяналтын албаны захирал, Дэд захирал, МХБ-ийн Гүйцэтгэх захирлаар тус тус дэвшин ажиллаж, МХБ-ийн барилгын засвар, боловсон хүчин, менежер, дилерүүдийг бэлтгэх, давтан сургах, биржийн дүрэм, журам, зааврыг боловсруулах, хэрэгжүүлэх ажилд идэвх санаачлага, үр бүтээлтэй ажилласан байна.



Түүнчлэн Монголын хөрөнгийн биржийн Хяналтын системийг боловсруулж, Хяналтын алба, Гишүүн пүүсийн албыг санаачлан байгуулж, үйл ажиллагааг нь удирдаж ирсэн бөгөөд 1998-2005 онуудад Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны (МҮЦАЭХ)-ны Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байжээ.

ҮЙЛ ЯВДАЛ

МХБ-ИЙН АЖИЛТНУУД ТӨРИЙН ӨНДӨР ДЭЭД ОДОН, МЕДАЛИАР ШАГНУУЛЛАА

Монгол улсад хөрөнгийн зах зээл үүсч, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК байгуулагдсаны 30-н жилийн ойг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа олон жил үр бүтээлтэй ажилласан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн ажилтнууд төрийн дээд одон медалиар шагнууллаа. Үүнд:

“Хөдөлмөрийн гавианы улаан тугийн одон”-гоор МХБ-ийн Хяналт, зохицуулалтын газрын мэргэжилтэн Ж.Нарантуяа, “Алтан гадас одон”-гоор МХБ-ийн Үйл ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн Д.Алдармаа болон Захиргаа, санхүүгийн газрын ажилтан П.Бямбаа нар тус тус шагнуулсан байна.

Олон жилийн хөдөлмөр зүтгэлээ төр түмэндээ үнэлүүлэн шагнал хүртсэн мэргэжилтнүүддээ баяр хүргэж, цаашдын ажил үйлсэд нь өндөр амжилт хүсье





АСГАТЫН МӨНГӨНИЙ ОРДЫГ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭНД ОРУУЛАХ ЧИГЛЭЛ БҮХИЙ ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН ХУРАЛДААН МХБ ДЭЭР БОЛЛОО



Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагуудад чиглэл өгөх Байнгын хорооны шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Энэхүү ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсгийн хуралдаан 2021 оны 2-р сарын 03-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн байранд хуралдлаа. Уг хуралдаанд Ажлын хэсгийн дарга УИХ-ын гишүүн Т.Аубакир, УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан, УИХ-ын гишүүн Т.Энхтүвшин, УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тлейхан, "Монголын



хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, Зөвлөх инженер Д.Бат-Эрдэнэ нар оролцлоо. Хуралдааны үеэр дэд ажлын хэсгийн гишүүн Зөвлөх инженер Д.Бат-Эрдэнэ, МХБ-ийн Бүртгэлийн албаны ахлах мэргэжилтэн Д.Нямдорж, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ийн Металлын төсөл хариуцсан захирал Г.Ганболд нар ордын геологийн нөхцөл болон МХБ-ийн үнэт цаасны бүртгэл, эрх зүйн зохицуулалтын талаар илтгэл танилцуулга хийв.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Ашигт малтмалын тухай хуулийн 5.6 дахь заалтад стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын

ҮЙЛ ЯВДАЛ

тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжаалахаар заасан байдаг бөгөөд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх тухай тусгагдсан байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА ОНЛАЙН ГОРИМООР ХЭВИЙН ЯВАГДАВ

Монгол Улсын Засгийн газар болон Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу 2021 оны 02 дугаар сарын 11 -ний өдрөөс 02 дугаар сарын 23-ны өдрийг хүртлэх хугацаанд Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжих шийдвэрийг гаргасантай холбогдуулан "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь дээрх хугацаанд (2021.02.12-ны өдөр буюу бүх нийтийн баярын өдрөөс бусад өдөр) бүрэн зайнаас ажиллах бөгөөд үнэт цаасны арилжаа онлайн горимоор хэвийн явагдав.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИЙН НЬ ХУВЬЦАА ХУДАЛДАН АВАХ ЭРХИЙН ХУГАЦААГ СУНГАВ



Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь 2019 оны 2-р сард хаагдсан хаалттай санхүүжилтийн хүрээнд гаргасан 10,265,222 ширхэг энгийн хувьцаа худалдан авах эрх буюу варрантын хугацааг гурван сараар буюу 2021 оны 5 -р сарын 28-ны өдөр хүртэл сунгахаар боллоо. Харин уг варрантыг хэрэгжүүлэх \$0.50-ын үнэ болон бусад нөхцлүүдийг өөрчлөөгүй байна.



"CFA RESEARCH CHALLENGE" ТЭМЦЭЭНД "АХИОМ" БАГ ТҮРҮҮЛЛЭЭ.



"Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК нь Монгол Улсад хөрөнгийн зах зээл үүссэний 30 жилийн ойг тохиолдуулан Монголын Итгэмжлэгдсэн Санхүүгийн Шинжээчдийн Нийгэмлэгээс 5 дахь жилдээ зохион байгуулж байгаа CFA Institute Research Challenge / Судалгааны Сорил/ тэмцээнийг хамтран зохион байгууллаа.

Энэ удаагийн тэмцээн нь цар тахалтай холбоотойгоор 2021 оны 1-р сарын 29-ний өдөр цахим хэлбэрээр болж 7 их, дээд сургуулийн 9 багийн 45 оюутан оролцсоноос Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн "АХИОМ" баг тэргүүн байранд орж, Ази Номхон далайн бүсийн тэмцээнд оролцох эрхээ авсан бол Монгол Улсын Их Сургуулийн "ТИТАНС" баг хоёрдугаар байр, Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн "МЕРАКИ" баг гуравдугаар байрыг тус тус эзэллээ.

Энэхүү уралдаан тэмцээн нь биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанид олон улсын стандарт шаардлагын дагуу шинжилгээ судалгаа хийдэг тул зах зээлд ажиллах мэргэшсэн шинжээчдийг бэлтгэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

НОГДОЛ АШИГ ТАРААХ ЭСЭХ ШИЙДВЭРЭЭ ИРҮҮЛЭЭГҮЙ КОМПАНИУДЫН АНХААРАЛД

Монголын хөрөнгийн биржийн бүртгэлтэй хувьцаат компаниуд нь Компанийн тухай хуулийн дагуу 2 дугаар сарын 19-ны дотор ТУЗ-ийг хуралдуулан ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрээ гаргаж баталгаажуулах ёстой билээ. 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар нийт 192 компаниас 65 компани хууль, журмын хэрэгжилтийг ханган ногдол ашигтай холбоотой шийдвэрээ ирүүлээд байна.

Нээлттэй хувьцаат компани нь ногдол ашиг тараах эсэх шийдвэрийг компанийн санхүү, үйл ажиллагааны нөхцөл байдал, цаашдын төлөвлөгөөтэй уялдуулан гаргаж, энэхүү шийдвэрээ олон нийтэд мэдээлэх үүрэгтэй билээ. Иймд шийдвэр ирүүлээгүй компаниуд хууль, журам, гэрээний үүргээ биелүүлж, мэдээллээ яаралтай ирүүлнэ үү.

ҮЙЛ ЯВДАЛ

НОГДОЛ АШИГ ТАРААХГҮЙ ТУХАЙ ШИЙДВЭР ИРҮҮЛСЭН КОМПАНИУД

Компанийн тухай хуулийн 46.5-д заасны дагуу нээлттэй хувьцаат компаниуд ногдол ашиг тараах эсэх шийдвэрээ санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор гаргасан байх зохицуулалттай байдаг. 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй дараах нэр бүхий 56 компаниуд санхүүгийн байдал болон цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН АНХААРАЛД

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хуралдаанаар "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журамд нэмэлт, өөрчлөлт, оруулах тухай" 45 дугаар тогтоолыг баталсан бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн 64, 65, 66 дугаар зүйлд заасны дагуу холбогдох нэмэлт, өөрчлөлтийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хянаад, 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр улсын нэгдсэн бүртгэлд хөдөлгөөн хийлээ.

Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр "Хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах" гэсэн бүлгийг нэмж оруулан хувьцаа эзэмшигчид хуралдаа онлайнаар оролцож, асуулт асуух, саналаа цахимаар өгөх, санал тооллогыг баталгаажуулах зэрэг нөхцөл, шаардлагыг зохицуулсан нь хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг нэмэгдүүлэх, жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоог сайжруулах ач холбогдолтой юм.



2020 ОНЫ НОГДОЛ АШГААС ТАРААГДАХ НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

Компанийн нэр	Ногдол ашиг тараах өдөр	Нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ	Нийт ногдол ашиг
1 "ТҮМЭН ШУВУУТ" ХК	2021.05.12-ны өдрөөс эхлэн	8 ₮	1,600,000,000
2 "ЛЭНДМН ББСБ" ХК	2021.04.30 өдөр	1.00 ₮	447,800,000
3 "ТАЛХ ЧИХЭР" ХК	2021.10.01-ний өдрөөс эхлэн	225 ₮	230,300,000
4 "ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ" ХК	2021.06.30-ны өдрийн дотор	0.2 ₮	199,226,790
5 "МОНГОЛ БАЗАЛТ" ХК	2021.06.30-ны өдөр	2.87 ₮	160,200,000
6 "МАХИМПЕКС" ХК	2021.10.01-ний өдрөөс эхлэн	80 ₮	304,057,680
7 "ГУТАЛ" ХК	2021.05.05-ны өдрөөс эхлэн	1,120 ₮	1,700,000,000
8 "УЛААНБААТАР БҮК" ХК	2021.06.01-ний өдрөөс эхлэн	30 ₮	3,946,425,000
9 "АРД ДААТГАЛ" ХК	2021.07.30-ны дотор	40 ₮	1,000,000,000
10 "УЛААНБААТАХ ХИВС" ХК	2021 оны 6 сард багтаан	600 ₮	242,897,400
11 "ТАХЬКО" ХК	2021.05.01-ний өдрийн дотор	108 ₮	128,500,000
12 "БОДЬ ДААТГАЛ" ХК	2021.12.31-ний өдрийн дотор	5 ₮	1,176,598,590
13 "АРД КРЕДИТ ББСБ" ХК	2021.06.30-ны өдрийн дотор	3.57 ₮	1,000,000,000
14 "АПУ" ХК	2021.12.31-ний өдрийн дотор	57.50 ₮	61,190,439,296
15 "БАЯНТЭЭГ" ХК	2021.12.01-ний өдөр	100 ₮	25,200,000
16 "АДУУНЧУЛУУН" ХК	2021.06.30-ний өдрийн дотор	40 ₮	126,000,000
17 "МОНГОЛЫН ЦАХ ХОЛБОО" ХК	2021.06.01-ний өдрөөс эхлэн	1 ₮	25,800,000
18 "МОНГОЛ ШУУДАН" ХК	2021.05.01-ний өдрөөс эхлэн	1.68 ₮	167,368,000
19 "МОНОС ХҮНС" ХК	2021.04.01-ний өдрөөс эхлэн	1 ₮	408,850,428
20 "Э-ТРАНС ЛОЖИСТИКС" ХК	2021.07.30-ны өдрийн дотор	5 ₮	231,000,000
21 "ДАРХАН НЭХИЙ" ХК	2021.12.31-ний өдрийн дотор	0.227 ₮	250,000,000
22 "МАНДАЛ ДААТГАЛ" ХК	2021.06.30-ны өдрийн дотор	3 ₮	1,872,904,800
23 "ГЕРМЕС ЦЕНТР" ХК	2021.03.15-ны өдрөөс эхлэн	4.8 ₮	377,006,405
24 "ИНВЕСКОР ББСБ" ХК	2021.04.30-ны өдрийн дотор	17 ₮	1,219,374,606
25 "ЭРДЭНЭТ СУВАРГА" ХК	2021.06.30-ны өдрийн дотор	5 ₮	780,270
26 "ТАЛЫН ГАЛ" ХК	2021.07.01-ний өдрийн дотор	50 ₮	34,700,000
27 "СҮҮ" ХК	2021.05.01-ний өдрөөс эхлэн	7.36 ₮	2,500,000,000
28 "ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ХК	2021.10.10-ны өдөр	155.89 ₮	1,600,000,000
29 "БАРИЛГА КОРПОРАЦИ" ХК		500 ₮	20,300,000
30 "ХҮРД" ХК	2021.06.30-ны өдрийн дотор	479 ₮	64,792,414
31 "ТАВАНТОЛГОЙ" ХК	2021.05.21-ний өдрөөс эхлэн	357 ₮	18,801,476,400
32 "АСБИ" ХК	2021.06.30-ны өдрийн дотор	90 ₮	5,711,040
НИЙТ			101.1 тэрбум төгрөг

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Сүхбаатарын талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747-2129



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN